

БАТЛАВ:

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш. Энхтуяа

Ш.ЭНХТУЯА

“ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ЭМИЙН ХАНГАМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ДЭЛХИЙН ПЛАТФОРМ” САНААЧЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХҮРЭЭНД ЭМИЙН ХАДГАЛАЛТ, ТҮГЭЭЛТИЙН СУУРЬ СТАНДАРТУУДЫГ
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

ҮНДЭСЛЭЛ:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас Америкийн Нэгдсэн Улсын Хүүхдийн хорт хавдрын судалгааны “Сэйнт Жүүд” (St. Jude) эмнэлэгтэй хамтран 2027 он хүртэл бага болон дунд орлоготой 50 улс оронд амьдарч буй хорт хавдраар өвчилсөн 120,000 орчим хүүхдэд нэн шаардлагатай эмийг санхүүгийн хүндрэлээс хамааралгүйгээр хүртээмжтэй олгож хангах төслийг хэрэгжүүлэх санаачлагыг 2021 оны 12 дугаар сард гаргасан. Үүний хүрээнд ДЭМБ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, АНУ-ын Хүүхдийн хорт хавдрын судалгааны “Сэйнт Жүүд” (St. Jude) эмнэлэг хамтран “Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ” санаачлагын хүрээнд эмийн хүртээмж, хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх гэж байна. Тус санаачлагын хүрээнд эхний ээлжинд ДЭМБ-ын 6 бүс бүрээс 1, нийт 6 улсыг сонгон, хүүхдийн хорт хавдрын эмчилгээнд нэн шаардлагатай 35 нэрийн эмийг үнэ төлбөргүйгээр нийлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улс нь дээрх санаачлагад ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсэд харьяалагдах 37 улс орноос сонгогдсон бөгөөд ингэснээр хүүхдэд зонхилон тохиолдож буй 6 төрлийн хорт хавдрын тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай ДЭМБ-ын “урьдчилан баталгаажуулалт”-д хамрагдсан буюу эмийн хатуу зохицуулалттай улс оронд үйлдвэрлэсэн чанар, аюулгүй байдлын стандартын өндөр шаардлагыг хангасан эмийг 2023-2027 онд үнэ төлбөргүйгээр хүлээн авах боломжийг бүрдүүлэх юм.

ЗОРИЛГО:

Хүүхдэд зонхилон тохиолдож буй 6 төрлийн хорт хавдрын эмчилгээний 31 нэрийн эмийг “Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ”-ын хүрээнд хүлээн авахад суурь стандартуудыг боловсруулж, хэрэгжүүлэхэд оршино.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

1. Химийн эмчилгээний /эс хордуулах/ эм бэлтгэх стандарт ажиллагааны заавар боловсруулах
2. Эмийн сангийн эм хүлээн авах, түгээх, хяналт тавих үйл ажиллагааны стандарт ажиллагааны заавар боловсруулах /хөргөгч, цахилгааны нөөц үүсгэврийн засварын төлөвлөгөө/

3. Эмийн хадгалалт, түгээлтийн стандарт боловсруулах
4. Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх талаар эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах
5. Эмийн нөөцийн агуулахын үйл ажиллагааг сайжруулах, сургалт зохион байгуулах

ХАМРАХ ХҮРЭЭ:

ЭМЯ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Зоонозын үндэсний төвийн Эмийн нөөцийн агуулах, ХАвдар судаллын үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газар, Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар

САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:


Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага – төсөв 54,091,500₮

ХУГАЦАА:

2023 оны 03 дугаар сарын 15-аас 06 дугаар сарын 30-ны өдөр

ХҮРЭХ ҮР ДҮН:

1. “Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ”-ын хүрээнд хүлээн авахад суурь стандартууд боловсрогдож, эм хүлээн авах бэлтгэл ажил хангагдсан байна.
2. Эм хүлээн авахад оролцогч талуудынэмийн хангамжийн түгээлтийн систем болон эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх талаар мэдлэг дээшилсэн байна.
3. Химийн эмчилгээний /эс хордуулах/ эм бэлтгэх талаар эмч, сувилагч, эм зүйчдийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.

ХЯНАСАН:  ОЮУН-ЭРДЭНЭ, ЭЭХХЗГ-ЫН ЭХГ-ЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:  МӨНХБААТАР, ЭЭХХЗГ-ЫН ЭХГ-ЫН
МЭРГЭЖИЛТЭН